

Хөрөг ярилцлагын “эрхэм зочны” үнэт зүйлсийг судалсан нь

Сүхээгийн Амартүвшин 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор, Улаанбаатар, Монгол Улс

AMUER 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн докторант

AMUERJIRIGALA

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн магистр

Хүлээн авсан - Received:
2024-03-27

Засварласан - Revised:
2024-04-17

Хэвлэгдсэн - Published:
2024-05-25

amartuvshin@msue.edu.mn

ORCID: [0000-0001-8940-3268](https://orcid.org/0000-0001-8940-3268)

aamuer80@gmail.com

ORCID: [0009-0009-6984-8513](https://orcid.org/0009-0009-6984-8513)



© 2024, Author(s)

Хураангуй: Хөрөг ярилцлагын нэвтрүүлгийн эрхэм зочин, хүмүүний “үнэт зүйлс”-ийг судлах нь агуулгын судалгааны нэг чухал сэдэв мөн. Олны танил болсон эрхэм хүмүүс өөрийн гэсэн үнэт зүйлтэй байдаг. Иймд хөрөг ярилцлагын нэвтрүүлгийн объект болох “монгол эрхэм хүмүүн”-ий эрхэмлэх үнэт зүйлсийг судалснаар нэвтрүүлгийн ур чадвар, агуулгын цөм зүйлийг тодруулах ач холбогдолтой. Энэхүү өгүүлэлдээ Монголд болон Өвөр монголд сүүлийн үед гарч байгаа “эрхэм хүмүүн”-ий хөрөг ярилцлагын нэвтрүүлгийн ярилцагчийн үнэт зүйлийг контент анализ, прэймингийн арга зүйгээр, мөн харьцуулан судлахыг зорив. Судалгааны үр дүнд “эрхэм хүмүүс”-т нийтлэг болон өвөрмөц үнэт зүйл бүрэлдэж, тухайн эзнийхээ мөн чанарыг илтгэж буй нь харагдлаа.

Түлхүүр үг: хөрөг ярилцлага, зочин ярилцагч, эрхэм хүмүүн, үнэт зүйл, үнэт зүйлийн давтамж

1.ОРШИЛ

Радио, телевизийн ярилцлагын нэвтрүүлэг дундаас хөрөг ярилцлагын нэвтрүүлэг сүүлийн үед ихээхэн дэлгэрч үзэгч сонсогчдын анхаарлыг татах болсон ч нэвтрүүлгийн бүтэц, агуулгын талаас уламжлалт байдлаар төдий, хангалтгүй судалжээ. Хөрөг ярилцлагын нэвтрүүлэг нь бие хүн, хамт олны дүр төрхийг олон талаас харуулж, үзэгч /сонсогчид/-дийн өмнө тэднийг өөрөөр нь нээж байдагт оршдог. Гэхдээ олонх хөрөг ярилцлагын баатар нь “хүндэт зочин”, “олны танил хүн” буюу бусдаас ялгарах үнэт зүйлтэй “эрхэм” байдаг бөгөөд энэ агуулгаар нь судалсан судалгаа огт хийгдээгүй байна. Иймд монгол улсын болон өвөр монголын хөрөг нэвтрүүлгийн “эрхэм хүмүүсийн” судлагдаагүй агуулгын талын зүйл болох “үнэт зүйлийн” харьцуулсан судалгаа хийхийг зорьсон юм.

Монгол соёл, уламжлал, ухамсар сэтгэлгээг даяаршлын энэ цаг үед хадгалан үлдэх үндэсний ухамсрын нэг хэлбэр болсон хөрөг ярилцлагыг ярилцагчийн үнэт зүйлийн талаас нь, түүнийг төлөвлөн ярилцагч хөтлөгчийн ур чадвар талаас нь судлах нь судалгааны шинэ эрэлхийлэл болно гэж үзлээ. Монгол улсын радио телевизийн ярилцлагууд дахь ийм шинж төрх бүхий шилдэг

нэвтрүүлэг цөөнгүй гарах болсон бөгөөд үүнийг өвөр монголын ижил төстэй нэвтрүүлгүүдтэй жишин харьцуулах судалгаа хийх эрдэм шинжилгээний эрэлт хэрэгцээ нэн тулгамдаж байгааг онцлон тус сэдвийг сонгосон болно.

Хүн бол нээж дуусашгүй ертөнц. Тиймээс ч телевизийн нэвтрүүлгийн төрөл жанр бүрд хөрөг нэвтрүүлгийн шинж чанар уусан холилдох нь зүйн хэрэг гэлтэй (Норовсүрэн.Л, 1995, хууд. 86). Гэхдээ хамгийн тохиромжтой хэлбэр бол хөрөг ярилцлага юм. Мөн баатрын туулж өнгөрүүлсэн амьдрал, туршлага, түүний зан төлөв хийгээд ертөнцийг үзэх үзлийг төлөөлөхүйц онцлог зэрэг хүмүүнд байхуйц хөтлөгчийн чиглүүлгээр өнцөг бүрийг тал талаас нь тодруулан хөрөг дүрийг нь яриагаар нь буюу ярилцагчийн өөрийн үгээр дүрслэн үзүүлдгээрээ онцлогтой. Иймийн тулд хөргийн баатар нь үзэгч, уншигчдад сургамж, дуурайл болохуйц амьдралын замнал туршлагатай хүн байх нь зүй юм. Тодруулбал, үгийн мэдрэмж, сэтгэх чадвараар ярилцагчаасаа илүү байвал баатрынхаа дотоод сэтгэлийг уншигч үзэгчдэд нэн толилуулж чадна (Зулькафиль.М, 2004, хууд. 234). Ийм хүний дотоод сэтгэлд эрхэмлэх үнэт зүйл нуугдаж байдаг бөгөөд түүнийг нь нээж гаргах нь хөрөг ярилцлагад чухал зорилт болж байдаг.

“Хөрөглөсөн ярилцлага (Интервью – протрет. Interview - portrait) бол манай сэтгүүл зүйд 1990-ээд оны эхэн үеэс орж ирсэн шинэ жанр юм. Ярилцагчийн сэтгэлийн ертөнцийг харилцан ярианы аргаар нээн харуулахад гол зорилго нь оршино” (Зулькафиль.М, 2004, хууд. 234). Тэгээд ч олны танил болсон эрхэм хүмүүс өөрийн гэсэн үнэт зүйлтэй болж чадсан гэж үзэж болно. Тэдний эрхэмлэдэг үнэт зүйлсийн тухай яриаг сонсох нь үзэгчдийн гол хүсэл, сонирхол юм. Иймд хөрөг ярилцлага бүтэх харилцан ярианы үндэс болсон яриа, ярилцлагын хэлбэрийг “асуулт, хариулт, асуулт, хариулт” гэсэн тогтсон бүтцээр нь тодорхойлохын зэрэгцээ зарим чөлөөт тайлбарламж, хүүрнэмж, тоочимжтой нь харгалзаж болох талтай (Амартүвшин.С., 2014, хууд. 45). Гэхдээ л үндсэн хэлбэрээр бол ярилцагчийн сэтгэлийн ертөнцийг харилцан ярианы аргаар нээн харуулахад гол зорилго нь оршино (Бэлгүүнзаяа.С, 2022, хууд. 89).

Сэтгүүл зүйн бичвэрүүд бичлэгийн төрөл зүйлийг “Мэдээллийн шинжтэй”, “Хөрөглөл бичлэгийн”, “Шинжлэлт бичлэг”-ийн гэсэн үндсэн гурван төрөл ангилалд хувааж үздэг. Профессор Ж.Батбаатар “Хөрөглөл бичвэр /profile/ нь хүний амьдралын нэг чухал хэсэг, нэг тодорхой асуудал, хэсгийг тусган дүрсэлсэн товч намтар өгүүлэмж юм. Дан ганц хүний ч биш юмс, аль нэг байгууллага газар, үйл явдал ер юуны тухай ч хөрөглөлд өгүүлж болно” (Батбаатар.Ж, 2023, хууд. 82) гэж үндсэн шинжийг нь тодорхойлсон байна.

1.1.Арга зүй, онолын баримтлал, эх материал:

1.1.1.Онолын ойлголт:

“Value” – валют гэх нэр томъёогоор орчин үед цаг үеийнхээ үнэт зүйлсийг ерөнхийд нь нэрлэдэг болсон. Энэ нь тухайн хүнд удаан хугацааны турш, тогтвортойгоор оршин байдаг итгэл үнэмшил юм. Үнэт зүйлийг хэмжих боломжгүй. Тиймээс үнэлж боломгүй үнэт зүйлс гэж бий. Бие хүн нийгэмд оршихдоо өөртөө өөрийн гэсэн итгэл үнэмшлийг бий болгон, тэрхүү итгэл үнэмшил нь өөрийгөө удирдан чиглүүлэхэд нөлөөлж байдаг (Sukhee, 2023, pp. 2-15) .

Үнэт зүйл гэдэг бол тухайн хувь хүн хийгээд бүлэг, хамт олны итгэл үнэмшил, эрхэмлэх сайн сайхны цогцыг хэлнэ. Үндэстнүүдийн хувьд үзэл санаа, соёл, төлөвшил, хандлагаасаа шалтгаалаад үнэт зүйлс нь өөр өөр. Тухайн үндэстнээс өөр хэн ч санаа зовдоггүй, зөвхөн үндэстэн өөрөө л санаа тавьдаг асуудлын нэг бол үндэстний соёл буюу үнэт зүйлийн тогтолцоо нь юм (Sukhee, 2024).

Хүн судлаач эрдэмтэн Kluckhohn үнэт зүйл гэдэг нь хувь хүний онцлог чанар болон бүлгийн өвөрмөц шинж чанарыг илэрхийлэх илэрхий болон илэрхий бус ойлголт бөгөөд боломжит хэв

шинж, арга барил, үйл ажиллагааны үр дүнгээс сонголт хийхэд нөлөөлдөг хүсүүштэй байдлын тухай ойлголт (Hofstede, 2001) гэж тодорхойлжээ. Rokeach (1972)-ийн тодорхойлолтод уг хүн өөр хэв маяг, оршин байх зорилгоос илүүд үзсэн тогтвортой үйл ажиллагааны хэв маяг, оршин байх зорилготой байхыг хэлнэ гэжээ.

Үнэт зүйл нь ямар ч тохиолдолд өөрчлөгдөшгүй тогтсон, бие хүний хувьд болон нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшлүүдийн цогц (McGuire, Garavan, Saha, & O'Donnell, 2006) юм. Мөн итгэл үнэмшил нь үнэт зүйлтэй маш ойр хэрэглэгддэг бөгөөд ихэнх тохиолдолд бие биеэс нь салгахын аргагүй ойлголт байдаг. Бие хүний амьдралын туршид болон оршихуйд үзэл бодол, хандлага, ерөнхий зан төлөв, шийдвэр гаргалт, харилцахуйд хамгийн чухал нөлөө үзүүлдэг зүйл нь түүний эрхэмлэгч үнэт зүйл юм (Санчес, 2000). Товчхондоо хүний зан үйлийг чиглүүлэгч итгэл үнэмшил /идеал/-ийг үнэт зүйл гэнэ. Тэгээд ч тодорхой нөхцөл байдлаас давсан, хүссэн зорилго эсвэл зан үйлийн хэлбэрт хамаарах итгэл үнэмшил гэж ойлгогддог бөгөөд энэ нь бусад үнэт зүйлстэй харьцуулахад харьцангуй чухал ач холбогдлоор зохион байгуулагддаг гэж үздэг (Schwartz, 2006). Хандлага болон үнэт зүйл хоорондын холбоо хамаарлыг судалсан Паул, Ханел, Колин Фoad нар “үнэт зүйлс, хандлагын хоорондын уялдаа холбоо нь бат бөх, уян хатан байдаг” (Paul H. P. Hanel, 31 August 2021) гэж дүгнэжээ.

1.1.2. Судлах арга зүй:

Онолын судалгаа хийх, түүвэр судалгаа, контент анализ, текст анализ, тайлал зүй, тайлбарлахуй, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ажиглалт хийх, харьцуулах аргаар судлав.

1.1.3. Судлах зүйл:

Судалгаандаа Монгол улсын телевизийн шилдэг 2 нэвтрүүлэг, Өвөр монголын радио телевизийн хорооны хөрөг ярилцлагын 2 нэвтрүүлгийн буюу нийт 4 нэвтрүүлгийн тус бүр хоёр дугаар, нийт 8 дугаарыг сонгов. Ингэхдээ хөрөг ярилцлагын зочдыг “өөрийн гэсэн үнэт зүйлтэй эрхэмүүд” гэх таамаглалаар харгалзан оролцогч эрхэм зочинд төвлөрч, мөн хийц хэлбэрийн хувьд ижил төстэй 4 нэвтрүүлэг сонгож авлаа. Үүнд:

- “Өвөр монголын радио телевиз хороо”-ны “Хүмүүн дууль” хөрөг ярилцлагын нэвтрүүлгийн 2 дугаар, “Чөлөөт ярилцлага” нэвтрүүлгийн 2 дугаар,
- Монгол улсын “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг, “Монголын үндэсний цаг” нэвтрүүлгийн 2 дугаар буюу дөрвөн хөрөг ярилцлагын нэвтрүүлгийн 8 дугаарын ярилцагчийн үнэт зүйлийн судалгаа, задлан шинжилгээ хийлээ.

Сонгож авсан 4 нэвтрүүлгийн товч танилцуулга, онцлогийг авч үзье:

“Чөлөөт ярилцлага” хөрөг ярилцлагын нэвтрүүлгээс Өвөр монголын алдарт дуучин Тэнгэр, Монгол улсын төрийн хошой шагналт нэрт хөгжмийн зохиолч Н.Жанчинноровын оролцсон хоёр дугаарыг судалгаандаа сонгон орууллаа.

“Хүмүүн тууль” хөрөг ярилцлагын нэвтрүүлгээс алдарт уртын дууч, улсын нэгдүгээр дэсийн тоглогч Загдсүрэн, радиогийн нэрт нэвтрүүлэгч Бадайн Бурам нарын оролцсон хоёр нэвтрүүлгийг сонгон судлав.

“Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлгээс Өвөр монголын алдарт дуучин Тэнгэр, өвөр монголын алдарт эрдэмтэн Боржгин Гэрэлтийн оролцсон хоёр нэвтрүүлгийг судалгаандаа сонгон авав.

“Монголын Үндэсний цаг” нэвтрүүлгээс “Зүүний сүвэгчнээсээ гарсан үндэсний хүмүүн Ломбын Эрхэмбаяр”, “Монгол малчнаа өмгөөлж яваа үндэсний хүмүүн Дамдины Баярсайхан”, түүний гэргий Оюунгэрэл нарын оролцсон хоёр дугаарыг судалгаандаа сонгон орууллаа.

2. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг:

Хөрөг ярилцлагын 8 нэвтрүүлгийг харьцуулан судлахдаа “хөрөг ярилцлага дахь ярилцагчийн үнэт

зүйл” хэмээх аспектыг онцлон судлав.

2.1.Ярилцагчийн үнэт зүйлийг тодруулсан контент анализ, дүн шинжилгээ

Хөрөг ярилцлагын “зочин” нь олны танил, эрхэм хүмүүс байдаг учир тэдний итгэл үнэмшил болсон, нандигнан эрхэмлэх үнэт зүйлийг хөндөн ярилцдаг агуулгын гол асуудлыг тус бүлэгт контент анализын аргаар задлан шинжилж боловсруулалт хийсэн болно.

Нэвтрүүлгүүдэд тухайн зочин оролцогчийн ярилцлагаас яриандаа чухалчилж, эрхэмлэн ярьсан үнэт зүйлсийг контент анализын аргаар түүвэрлэж, түүврээр илрүүлсэн “ярилцагчийн үнэт зүйлс”-ийг бүртгэн давтамжийг нь тодруулсан юм.

Хүснэгт 1. Ярилцагчийн үнэт зүйлийн давтамж

Нэвтрүүлгийн нэр	Монгол тулгатны 100 эрхэм		Монголын үндсэний цаг		Чөлөөт ярилцлага		Хүмүүн тууль		Үр дүн
	Тэнгэр	Гэрэлт	Л.Эрхэмбаяр	Д.Баярсайхан	Тэнгэр	Н.Жанцанноров	Загдсүрэн	Бурам	нийт
1.Эх орон	3	1	0	0	0	0	0	0	4
2.Уламжлал	0	1	1	3	0	1	4	0	10
3.Нутаг	1	0	0	0	4	2	1	1	9
4.Өв соёл	2	0	0	1	0	0	1	0	4
5.Чингис	1	3	0	0	1	0	0	0	5
6.Үндэстэн	5	4	0	0	3	8	1	1	22
7.Хариуцлага	1	0	2	1	0	2	2	6	14
8.Аав, ээж	1	3	1	1	0	0	2	0	8
9.Үр хүүхэд	2	0	1	2	1	0	0	0	6
10.Хань ижил	1	0	0	3	0	0	0	1	5
11.Эх хэл	0	5	0	0	0	0	0	1	6
12.Монгол соёл	2	2	0	0	0	1	2	0	7
13.Хойч үе	1	1	2	1	0	0	1	1	7
14.Мэргэжил, боловсрол	1	3	3	2	0	3	1	7	20
15.Авьяас чадвар	1	0	2	1	0	2	2	1	9
16.Хамт олон	0	1	4	1	0	0	0	3	9
17.Хичээл зүтгэл	0	2	0	2	0	0	0	2	6
Тухайн хүний үнэт зүйлсийн давтамж	21	26	16	18	9	19	17	24	150
<i>Тухайн хүмүүний ярьсан үнэт зүйлийн төрөл</i>	<i>13</i>	<i>11</i>	<i>8</i>	<i>11</i>	<i>4</i>	<i>8</i>	<i>10</i>	<i>10</i>	<i>4< 13</i>

Ярилцагчийн үнэт зүйлийн давтамжийг хүснэгтлэн гаргаж, ажиглалт хийснээр гурван чухал онцлог байгааг тодорхойлон тэдгээрийг томъёолж, задлан шинжилгээ хийж, тайлбарласан юм.


1. Хамгийн олон давтамжтай яригдсан буюу тухайлсан эрхэмлэх үнэт зүйлс
2. Ярилцагчдын тухайн нэвтрүүлэгт ярьсан үнэт зүйлсийн бүрдүүлбэр
3. Ярилцлагын түлхүүр үнэт зүйл буюу ярилцагч бүрийн эрхэм үнэт зүйл

Ингээд эдгээр үнэт зүйлсийн онцлогийг тус бүрт нь, нэвтрүүлэг бүрээр буюу ярилцагч болгоноор авч үзье:

Хамгийн олон давтамжтай яригдсан буюу тухайлсан эрхэмлэх үнэт зүйлс

1. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлгийн зочин алдарт дүүчин Тэнгэрийн ярилцлага дахь хамгийн олон давтагдсан тухайлсан үнэт зүйлс:

График 1. “Монгол тулгатны 100 эрхэм”-д Тэнгэрийн ярьсан үнэт зүйлийн давтамж



Эндээс харвал Тэнгэр тус нэвтрүүлэгт “Үндэстэн” хэмээх үнэт зүйлийг амьдралын хамгийн эрхэм зүйл хэмээн мөрдлөг болгож иржээ. Энэхүү үнэт зүйлс давтагдахдаа 5 удаа дараах байдлаар яригдсан байна. Эдгээрээс 2 нь үндэс угсаагаараа бахархах үзэл санааг илтгэсэн яриа байв.

- Би ямарч газар дуулсан ч хамгийн сүүлийн хоёр мөрийг хятадаар дуулдаг, хятад хүмүүн бүгд мэднэ, дагаад бүгд “**би монгол хүмүүн**” гэж дуулдаг.
- Би ямар нэг шийдвэрлэж дийлэхгүй бэрх явдал таарвал **өөрийгөө би монгол болсны хувьд заавал чадах хэрэгтэй** гэж зоригжуулдаг.

гэсэн яриануудаас түүний үндэсний үзэл, үндэстнээ гэсэн үнэт зүйл, эрхэмлэл тодорхой харагдаж байна. Мөн дараах ярианд үндэстнээ хайрлах ухамсар сэтгэлгээг илэрхийлсэн байгаа нь ажиглагдлаа.


- Би заримдаа монголоо шүүмжилдэг, гэвч бусад үндэстэн муулахыг тэвчдэггүй.
- Монголчууд монгол хүмүүнээ хайрлаж явна. Монгол хүмүүнийг гагцхан монгол хүмүүн л хайрлана. Өөр хүмүүн хайрлахгүй.
- Би монгол хүмүүн болсны хувьд монгол хүндээ жаахан юм хийе гэсэн бодол байна.

хэмээн эрхэмлэдэг үнэт зүйлээ хэрхэн хайрлах, хамгаалах, нандигнахыг ухааруулсан аястай яриа хэллэг илэрч байв.

2. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлгийн зочин Эрдэмтэн Боржигин Гэрэлтийн ярилцлага

дахь хамгийн олон давтагдсан тухайлсан үнэт зүйлс:

График 2. “Монгол тулгатны 100 эрхэм”-д Гэрэлтийн ярьсан үнэт зүйлийн давтамж



Гэрэлтийн “эх хэл” хэмээх үнэт зүйлийг амьдралын хамгийн эрхэм зүйл болгон мөрдлөг болгож иржээ. Энэхүү үнэт зүйлс давтагдахдаа 5 удаа дараах байдлаар яригдсан байна. Мөн “үндэстэн” хэмээх үнэт зүйл 4 давтагдсан болон олон үнэт зүйлийг ярьсан нь түүний үнэт зүйлийн бүрдүүлбэр ямар арвин болохыг илтгэж байна.

“Эх хэл” хэмээх үнэт зүйлээ илэрхийлэхдээ тэрбээр:

- Би олон улсын хуралд оролцохдоо эхлэнгүүт монголоор мэндлээд, дараа нь англиар мэндлээд, монгол англитай хольж ярьдаг.

хэмээн монгол хэлээ яаж эрхэмлэдэгээ бахархан ярьсан бол

- Харамсалтай нь миний хүүхэн хятадаар сурчихсан. Япон хэл нь хятад хэлээсээ сайн, хятад хэл нь монгол хэлээсээ сайн. Би охиныгоо эх хэлдээ сайн болгох юмсан гэж бодоод байна даа.
- Өвөр монголчууд одоо хүүхдүүдээ өөр хэлээр сургаад монгол хэлгүй болохоос их айдаг юм.
- Бид бол монголоороо байсан. Бидний хүүхэд монгол хэлтэйгээ байж чадах уу гэдэг бол их асуудал болсон.

гэх мэтээр эрхэмлэн нандигнадаг “эх хэл”-ээ ирээдүй болсон хүүхдүүд нь ихэд эмзэглэн халаглан ярьж байгаагаас түүний эрхэм зүйлдээ хандах чин сэтгэлийн хандлагыг илтгэж байв. Мөн “Дээр удаа Буриадад хуралд оролцоход зууны 90 хувийн буриад, халх, өвөр монголчууд сууж байгаад оросоор яриад байдаг, англиар яриад байдаг. Яагаад монголоор ярьж болдоггүй вэ?” гэх халаглалаас мөн л эх хэлээ хамгаалан уламжлах гэсэн бодол сэтгэлгээ нь тодоос тод илрэн гарчээ.

3. “Монголын үндсэний цаг” нэвтрүүлэгт “үндсэний хүмүүн” Ломбын Эрхэмбаяр” ярилцлага дахь хамгийн олон давтагдсан тухайлсан үнэт зүйлс:

График 3. “Монгол тулгатны 100 эрхэм”-д Эрхэмбаярын ярьсан үнэт зүйлийн давтамж



Ломбын Эрхэмбаяр “Хамт олон” хэмээх үнэт зүйлийг амьдралын хамгийн эрхэм зүйл болгон мөрдлөг болгож иржээ. Энэхүү үнэт зүйлс давтагдахдаа 4 удаа дараах байдлаар яригдсан байна.

- *Хүмүүстэй харилцаж , хамт нийттэй баг болж ажиллана гэдэг бол ганцаар бизнес хийхтэй шал өөр юм байна*
- *Хамт ажиллагсаддаа шударга бай*
- *Түмэн шувуут түмний компани*

гэсэн яриануудаас хувийн бизнес хийж байснаасаа орон нутагт очиж олон нийтийг удирдан даргалан ажиллахдаа, бас хувийн компаниа түмний компани болгон олон нийттэй хамтрахдаа хамт олонтой ажиллах ямар байдаг, хамт олны хүчин чадал хэр их байдгийг мэдрэн эрхэмлэсэн үг билээ .

- *Бид нар нийлж л дараа дараа үеэ бэлтгэхгүй бол.....*

хэмээн ярьснаас нь дараа хойч үеэ хүртэл ямар нэгэн хүмүүн ганцаар бэлтгэх биш харин хамт олноороо сэтгэл гаргаж бэлтгэх хэрэгтэй хэмээн хамт олны чухал чанарыг дахин ярьсан төдийгүй бидний дараа дараагийн шилдэг хамт олныг бэлтгэн гаргаж өнөд үргэлжлэхийн үнэн чанарыг ярьжээ .

4. “Монголын үндсэний цаг” нэвтрүүлэгт “үндсэний хүмүүн” Д. Баярсайханы ярилцлага дахь хамгийн олон давтагдсан үнэт зүйлс:

График 4. “Монгол тулгатны 100 эрхэм”-д Д.Баярсайханы ярьсан үнэт зүйлийн давтамж



Дамдины Баярсайхан “Уламжлал”, “Хань ижил” хэмээх үнэт зүйлийг амьдралын хамгийн эрхэм зүйл болгож иржээ. Энэхүү үнэт зүйлс давтагдахдаа тус бүр 3 удаа дараах байдлаар яригдсан байна.

- *Аав ээжээсээ л өвлөж авсан даа...*
- *Монгол хүмүүний өөрийнх нь, үндсэн дээдсийнхээ юмуудыг өвлөж байгаа, өвлүүлж байх, үр хүүхэд ирээдүйд л хэрэгтэй байх гэж үзэж байна*
- *Эцгийн маань үндсэн тамга нь монгол үсгийн “п” тамга , тэрнийг л уламжлан авч явж байна даа.*


гэсэн яриануудаас өөрийн аав ээжээсээ энэ монголын өв соёлыг өвлөн авсныгаа юу юунаас илүү эрхэмлэн үзэж байгааг тод харуулах төдийгүй дараа дараа үеийн үр ач нартаа энэ үнэт соёл зан заншлаа өвлүүлэн уламжлахыг бодож ухамсарлаж явж байгаа нь тод харагдана.

- *Ханийнхаа буянд энэ нэвтрүүлэгт оролцож байгаадаа их л баярлаж байна даа.*
- *Мал эмнэлгийн ажлаа муу ханийнхаа л буянд өдий жар гартал хийж байна*
- *Тэр хугацаанд яаж нөхрөө энэ өвчнөөс салгаж авах, үр хүүхэддээ эцгийг нь амьд харуулах сан л гэсэн бодол тээж байсан*

гэж Дамдины Баярсайхан гуайн эхнэр Оюунгэрэл олон дахин хань ижлийн тухай ярьснаас монгол бүсгүйчүүд гэрийн эзэн, эр нөхөр, хань ижлээ хэрхэн хүндэлж, эрхэмлэн дээдэлж явдгийг олж харж болно.

5. “Чөлөөт ярилцлага” нэвтрүүлгийн зочин Алдарт дуучин Тэнгэрийн ярилцлага дахь хамгийн олон давтагдсан тухайлсан үнэт зүйлс:

График 5. “Монгол тулгатны 100 эрхэм”-д Тэнгэрийн ярьсан үнэт зүйлийн давтамж



Тэнгэр “Нутаг”, “Үндэстэн” хэмээх 2 үнэт зүйлийг амьдралын хамгийн эрхэм зүйл болгож иржээ. Энэхүү үнэт зүйлс давтагдахдаа 4 удаа дараах байдлаар яригдсан байна.

- *Тэр үед тал нутгийг торлож байсан ...* гэж харамсан ярьсан нь аль эрт өвөр монгол оронд тал нутгийг торлож, байгалийн жам хуулийг эвдэн сүйтгэж байгаад сэтгэл эмзэглэж, нутаг газраа хайрлаж байсан нь харагддаг бол
- *Нэг хүмүүнд хаа явсан ч түүний сэтгэлд хамгийн сайхан газар бол нутаг нь.*
- *Хүмүүн нас нэмэгдэхийг дагалдан нутгаа нэн илүү хайрлах болдог юм байна, энэ бол хүмүүний нэг өвөрмөц онцлог.*
- ***Нутгаа хайрлавал улсаа хайрласантай адил***


гэсэн нь нутаг ус хэмээгч эрхэм үнэт зүйлээ ярьж, тодруулжээ.

- ***“Тэнгэр” нэрэмжит дуу бүжгийн бүлгэмийг байгуулья гэж бодож байна. Жинхэнэ монгол дуу, урлагийг дэлхийд гаргана***

хэмээн ярьсны гол санаа нь монгол хэмээх үндэстэнийхээ дуу урлагийг дэлхийд таниулах, үндэстэнээ дэлхийд тунхаглаж яваагаа илтгэж, “үндэстэнээ” юу юунаас илүү эрхэмлэж байгааг тод харуулсан төдийгүй дуучин Тэнгэр монгол тулгатны 100 эрхэм нэвтрүүлэгт ч “үндэстэн” хэмээх үнэт зүйлийг онцлон олон ярьсантай нь холбон үзвэл энэ хүмүүний амьдралын хамгийн эрхэм үнэт зүйл яах аргагүй “Үндэстэн” болох нь тодорч байна .

6. “Чөлөөт ярилцлага” нэвтрүүлгийн зочин Төрийн хошой шагналт, нэрт хөгжмийн зохиолч Нацагийн Жанчинноровын ярилцлага дахь хамгийн олон давтагдсан тухайлсан үнэт зүйлс:

График 6. “Чөлөөт ярилцлага” -д Н.Жанчинноровын ярьсан үнэт зүйлийн давтамж



Нацагийн Жанцанноров “Үндэстэн” хэмээх үнэт зүйлийг амьдралын хамгийн эрхэм зүйл болгож иржээ. Энэхүү үнэт зүйлс давтагдахдаа 8 удаа дараах байдлаар яригдсан байна.

- *Би анх Өвөр монголд 1989 онд ирж байсан. Түүнээс хойш тасралтгүй ирж л байна. Ер нь бол энд ирээд нэг гадаадад ирчихлээ гэсэн сэтгэгдэл төрдөггүй.*
- *Энд бол монголоороо ярина. Амьдрал бол нэг л зүйлийн төлөө явчихдаг учраас бие биенээ ойлголцоно. Тиймч учраас хүмүүний газар ирчихлээ гэж бодогдох юм байдаггүй шүү.*
- *Өөрийн үндэстэн, өөрийнхөө үндэстний юмыг ойлгохгүй байна гэж юу байхав. Өөрөөр хэлбэл өвөр монголчуудын уран бүтээл гэдэг маань монгол үндэстэний л уран бүтээл шүү дээ. Тийм учраас бидний хооронд сэтгэхүйн зөрүү алга, сэтгэлгэний зөрүү алга.*
- *Миний хувьд энэ монгол улсын, өвөр монголын гэсэн ухагдахуун байхгүй. Адилхан монгол үндэстэн.*

хэмээн ар, өвөр монгол бол нэг үндэстэн ястан гэдгийг олон дахин давтаж онцлон ярьснаас нь бодон сэтгэж явдаг төдийгүй улс орон газар нутгийн хил хязгаараас илүү дэлхийгээр тархан суурьшсан бүх монгол үндэстэн бол нэг гэр бүл гэдэг үндэстэний үзэл санааг дээдэлж явдаг нь тодорхой харагдана .

- *1988 онд хийсэн “Мандухай сэцэн хатан” киноны хөгжим бол гарцаагүй, энэ бол миний ололт төдийгүй монголчуудын ололт шүү. Монголчуудын наяд оны төгсгөлийн үндэстэнээ гэх сэтгэлгээний нэг том дуулал болж байгаа юм.*
- *Би нэг их гоёж гангалдаггүй. Одон тэмдэг зүүдэггүй. Монгол дээлээ ч өмсдөггүй. Ер нь гаднаа монгол байхаасаа дотроо монгол байх юмсан гэж тэгж л шатаж явдаг хүмүүн шүү.*
- *Монгол хүн монгол хүмүүн шиг байгаасай л гэж боддог.*
- *Хэдийчинээ өөрийнхөө үндэс угсаа, үндэстэний сэтгэлгээ, үндэстэний амьдрах арга зарчмаа гүн хадгалж чадна уу төдийчинээ л удаан тэснэ.*

гэсэн яриануудаас өөрийнх нь амжилт бүтээл хүртэл энэ монгол үндэстэнийх, өөрөө гаднаа чимж монгол болж харагдахаасаа илүүтэй үнэн голоосоо, зүрх сэтгэлээсээ монгол үндэстэн байх нь чухал гэдгийг уриалж хэлсэн далд утга харагдана. Сүүлийн өгүүлбэртээ үнэт зүйлийнхээ амьдралд үзүүлэх нөлөө, утга учрыг эрхэмлэн, учирлан тайлжээ.

7. “Хүмүүн түүль” нэвтрүүлгийн зочин Улсын нэгдүгээр дэсийн тоглогч, алдарт уртын дүүчин Загдсүрэнийн ярилцлага дахь хамгийн олон давтагдсан тухайлсан үнэт зүйлс:

График 7. “Хүмүүн түүль” -д дүүчин Загдсүрэнийн ярьсан үнэт зүйлийн давтамж



Загдсүрэн “Уламжлал” хэмээх үнэт зүйлийг амьдралын хамгийн эрхэм зүйл болгон иржээ. Энэхүү үнэт зүйл давтагдахдаа 4 удаа дараах байдлаар яригдсан байна.

- Тэгээд тэр настан өглөө эрт босчихоод уртын дууны аян дээр үнээ ивэлгээд. Тэр үед л “үнээ ивэлгэхийг” сонсож байжээ
- Хажуу айлын Цамба гуай гэж өндөр том биетэй лам хүн байсан. Сайхан дуулна. Энэ хүмүүний дуулахыг олон сонсож хар багаасаа уртын дууны их соёл суужээ

гэж уртын сайхан дуугаа ахмад буурлуудаас хэрхэн өвлөн авч сурснаа ярьсан нь дээр үеийн буурлуудынхаа эрдэм ухааныг бишрэн хүндэлж явааг харуулах төдийгүй өвлөн уламжлахын чухал чанарыг бүр тодруулан гаргажээ.


- Дуулж чаддаг, ярьж чаддаг, зааж чаддаг тал уруу нь хөгжүүлэе гэж ажилласан.
- 2002 онд Москва хотод очиж цуглаад гэнэтхэн уртын дуугаа дуулж шингээж үлдээхгүй бол болохгүй гэдэг бодол ороод дал, наян дуугаа шингээсэн юм аа.

хэмээн ярьсны ахмад үеэсээ өвлөн авсан эрдэм ухаан өв соёлоо зөвхөн өөрөө л сурч хэрэглээд зогсошгүй дараа үедээ уламжлан өгч өвлөн үргэлжлүүлэхийг бодон ажиллаж яваа нь тод харагдана.

8. “Хүмүүн тууль” нэвтрүүлгийн зочин Хятадын олон улсын радиогийн алдарт нэвтрүүлэгч Бадайн Бурамын ярицлага дахь үнэт зүйлийн бүрдүүлбэр:

8. “Хүмүүн тууль” нэвтрүүлгийн зочин Хятадын олон улсын радиогийн алдарт нэвтрүүлэгч Бадайн Бурамын ярицлага дахь хамгийн олон давтагдсан тухайлсан үнэт зүйлс:

График 8. “Хүмүүн тууль” -д Бадайн Бурамын ярьсан үнэт зүйлийн давтамж



Эндээс харвал Бадайн Бурам “Мэргэжил, боловсрол” хэмээх үнэт зүйлийг амьдралын хамгийн эрхэм зүйл болгон мөрдлөг болгож иржээ. Энэхүү үнэт зүйлс давтагдахдаа 7 удаа дараах байдлаар яригдсан байна.

- *Хэл нь төрөлх уран биш, хэлний боловсролгүй учраас нэвтрүүлэгчийн соёл алдагджээ. Одоо манай монгол нэвтрүүлэгч хөтлөгчийн дотор төвийн бүх улсын нэвтрүүлэгчтэй зэрэгцэх нэвтрүүлэгч бол өдрийн од шиг болжээ.*
- *Төрөлх дөрвөн нөхцөл, энэ байгаад боловсрохгүй, сурахгүй, мэдлэгээ өргөжүүлэхгүй, чармайхгүй бол сайн нэвтрүүлэгч болж чадахгүй. Энэ үндсэн нөхцөл дээрээ чармайх нь гурван хувиар бодвол, үндсэн нөхцөл нэг хувь, чармайлт хоёр хувийг эзэлнэ.*
- *Би бол дээшээ сургууль давшиж, өргөн мэдэлгэтэй хүмүүн болж, шинжлэх ажиллагаа хийе гэж бодсон*
- *Нөгөө нэг нь хувь хүмүүний зан. Би багаасаа мэдлэгтэй хүмүүнийг бишрэн хүндэтгэнэ. Би бас энэ хүмүүнтэй адил өргөн мэдлэгтэй болохыг хүснэ.*
- *Би яагаад сурахыг ингэж чухалчилсан бэ гэвэл, нэг нь уулаасаа мэдлэг сорьё гэж, нөгөө нь намайг дээшээ сургуульд явуулсангүйд их харамсаж зовно. Ингээд ямар нэг аргаар гэсэн нөхөөд авах юмсан гэж боддог байв.*
- *Гэнэтхэн нэг өдөр олж сонсоод би радиодоо орчих шахсан. Эх сайхан монгол хэлээр энэ дэлхий дээр хамгийн сайхан ярьдаг хүмүүн гэж бодсон. Энэ хүмүүн шиг ярих юмсан гэж бодно*

гэж бүх ярилцлагад хамгийн олон удаа мэргэжил боловсролын тухай дахин ярьсан, тэгээд бүр тэтгэвэрт гараад наян насыг давсан ч бас л суралцаж явна гэж ярьснаас нь энэ хүмүүн бүхий л амьдралынхаа туршид суралцан боловсорч мэргэжлийг дээшлүүлэхийг хамгийн эрхэмд үзэж, жинхэнэ нэвтрүүлэгч буюу тухайн мэргэжилдээ мэргэшсэн хүмүүн болохоор хичээн зүтгэсэн нь тод харагдана.

Ярилцагчдын тухайн нэвтрүүлэгт хөндөж ярьсан үнэт зүйлсийн бүрдүүлбэр

Энэ бүрдүүлбэр нь ярилцагч бүрт ярилцлагаараа хэлсэн үнэт зүйлсийн цогц юм. Нэг ярилцлагаар ярилцагч хэдэн үнэт зүйл ярьж байгааг тодорхойлсон шинжилгээг графикаар харуулъя.


График 9. Ярилцагчдын үнэт зүйлийн бүрдүүлбэр /тоогоор/



Эндээс харвал Алдарт дуучин Тэнгэр хамгийн олон үнэт зүйлийг хамруулж ярьжээ. Дундажаар нэг ярилцагч нэвтрүүлгээр 8 үнэт зүйл ярьсан байхад Тэнгэр “Чөлөөт ярилцлага” нэвтрүүлгээр 4 үнэт зүйлээ ярьсан байна.

Тухайлбал судалгаанд нийт ярилцагчдын ярьсан үнэт зүйлсийн бүрдүүлбэр болох 17 үнэт зүйлийн 13 үнэт зүйлийг хамруулж ярьсаныг графикаар харуулбал:

График 10. Тэнгэрийн ярьсан үнэт зүйлийн бүрдүүлбэр /тоогоор/



Харин “Чөлөөт ярилцлага”-аар Тэнгэрийн ярьсан 4 үнэт зүйлд ажиглалт хийвэл цөөн ч гэсэн хамгийн эрхмээр чухалчилж ярьжээ. “Чингис”, “Монгол соёл”, “Хань ижил”, “Үр хүүхэд” гэсэн 4 үнэт зүйлийг ярихдаа дараах хариултыг өгсөн байлаа.

“Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэгт “Хань ижил” хэмээх үнэт зүйлийн талаар **“Одоо бодоход миний хамгийн том шагнал миний эхнэр байх”** хэмээн бүхнээс эрхэмд үнэлэн хэлжээ. Тэгвэл тус нэвтрүүлгээр “Чингис” хэмээх эрхэмлэлээ “Чингис хаан гэж бол яг **монголын бурхан** байгаа, бүх дэлхийн монголчууд **Чингис хаанаа шүтэж явах хэрэгтэй”** гэж бахархан бишрэл шүтлэгийн үнэт зүйл болгон илэрхийлсэн байна. Мөн “Чөлөөт ярилцлага” нэвтрүүлгээр “Чингис хаан бол бүх монголчуудын агуу их хүмүүн. Би нэг монгол хүмүүн болсны хувьд **Чингис хаанаа магтан дуулах нь амь насны чухал нэг зүйл мөн”** гэж өөр байдлаар давтан хэлсэн нь “Чингис” түүний үнэт зүйл болж тогтсоныг давхар гэрчилжээ.

Мэдээж алдарт дуучин маань өв соёл, монгол соёлыг тээгч гэдэг нь тодорхой учир “монгол соёл” хэмээх үнэт зүйлийг эрхэмлэн ярьжээ. “*Чингис хааны бий болгосон монгол улсын ард, монгол хэлтэн биднээр болбол дэлхийн бөмбөрцгийн хойт хэсгийн нүүдэлчин ардын түүх соёлыг уламжилж хадгалаад од болтол амьдаар байлгаж байгаа үндэстэн. Иймээс бид “монгол” гэж гагцхан өөрийн үндэстэнийхээ төлөө ярьж байгаа биш дэлхийн соёлыг авч явахын төлөө гэж би бодоод байдаг юм*” гэсэн байна.

Түүний хувьд хэдийгээр нутаг, үндэстэн, хань ижил, хойч үе, авьяас чадвар гэсэн үнэт зүйлсийг нэг л хариултаар хэлсэн боловч хамгийн эрхэм зүйл болох нь хариултаар ажиглагдаж байлаа.

Ярилцагчдын хувьд хамгийн олон давтагдсан үнэт зүйлс

Энэхүү ажиглалтаар ярилцагчид аль үнэт зүйлийг хамгийн олон давхцалтай ярьж вэ? Чухам яагаад, хэрхэн тухайн үнэт зүйлийг тэд ярьж вэ? гэдэгт хариулт олохыг зорьсон. Ингээд түүвэр болон ерөнхий хүснэгтийг хаьцуулж үзвэл 4 үнэт зүйл хамгийн олон ярилцагчийн ярианд дурдагджээ.

Хүснэгт 2. Ярилцагчдын хамгийн олон давтагдсан үнэт зүйлс

Үнэт зүйлс	Мт100э-1	Мт100э-	Мүц -1	Мүц -2	Чя-1	Чя-2	Хт-1	Хт-2	нийт
------------	----------	---------	--------	--------	------	------	------	------	------

		2							
Үндэстэн	5	4	0	0	3	8	1	1	22
Хариуцлага	1	0	2	1	0	2	2	6	14
Хойч үе	1	1	2	1	0	0	1	1	7
Мэргэжил, боловсрол	1	3	3	2	0	3	1	7	20

“Үндэстэн” хэмээх үнэт зүйлийг 8 ярилцагчаас шинжлэх ухааны эрдэмтэн, урлаг соёлын алдартан, удам дамжсан малчин, улстаа алдартай нэвтрүүлэгчийг багтаасан 6 хүмүүн 22 удаа давтан ярьснаар судалгаанд хамгийн олон давтагдсан үнэт зүйл болж байна.

Бага буурай үндэстнүүдэд урьд байгаагүй их нөлөө авчирч байгаа даяарчлалын нөлөөнд өнөөдөр эрхэм хүмүүсээс аваад эгэл жирийн малчин ард хүртэл хэрхэн бусад үндэстэний соёлд уусчихгүйгээр “даяарчлал”-ын дунд өөрийнхөөрөө “дангааршин” үлдэж чадахыг юу юунаас илүү эрхэмлэн монгол хэмээх үндэстэнийхээ ирээдүйн төлөө цаг ямагт санааширч байгаа нь тодорхой харагдаж байна.

“Хариуцлага” хэмээх үнэт зүйлийг 8 ярилцагчаас 6 хүмүүн 14 удаа давтан ярьснаар үзвэл амжилт бүтээлийн оргилд яваа эрхэм хүмүүс ажил амьдрал дунд, аливаа зүйлийн өмнө хариуцлагатай байхыг ихэд эрхэмлэн үздэг нь ажиглагдаж байв.

“Хойч үе” хэмээх үнэт зүйлийг 8 ярилцагчаас мөн 6 ярилцагч ярьжээ. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэгт дуучин Тэнгэр: “Энэ олон үндэстний дотор монгол үндэстэн юу юугаараа бахархмаар, юугаараа бид илүү вэ?” гэх асуултад “Манай монголчууд одоо ч өвс мод хэрэглэхдээ хүртэл үндсийг нь малтахгүй. Хойч үедээ үлдээнэ” гэж хариулсан нь монголчуудын байгаль дэлхийдээ хэдий хайртайг харуулсан төдийгүй үгийн гол санаа нь “хойч үе”-ээ хайрлах эрхэм санааг тээжээ. Монголчууд ирээдүй хойч үеийнхээ төлөө эд хөрөнгө цуглуулж өгөхөөсөө илүүтэй эх байгалийг нь бүрэн бүтэн үлдээх нь хойч үедээ өвлүүлэх өв гэж ухамсарладаг гүн ухаан тодорч байна.

“Мэргэжил, боловсрол” хэмээх үнэт зүйлийг 8 ярилцагчаас 7 ярилцагч 20 удаа ярьснаас үзвэл амжилт бүтээлийн оргилд яваа эрхэм хүмүүс “мэргэжил боловсрол”-ыг машид эрхэмлэн сайн эзэмшиж, цаг ямагт дээшлүүлэхээр хичээн зүтгэж явдаг нь ажиглагдана. Энэ бол орчин цагийн хувь хүний хамгийн чухал үнэт зүйл болох нь тэдний яриагаар ч баталгаажиж байгаа бөгөөд үүнийг нэвтрүүлгээр дамжуулан ярих нь тус үнэт зүйлийг эрхэмлэх үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Ярилцлагын түлхүүр үнэт зүйл буюу ярилцагч тус тусын хамгийн эрхэм үнэт зүйл

Хэдийгээр дээрх хоёр онцлог бүхий задлан шинжилгээ, үнэт зүйлийн талаарх үнэлгээ хангалттай мэт боловч, тухайн нэвтрүүлгээр ярилцагч маань олон удаа эс байлаа ч, ярилцагчдын олонтаа давтсан үнэт зүйлийн давтамж өнөдөр байлаа ч, хамгийн чухал зүйл болох ярилцагч хувьдаа хамгийн эрхэмлэж нэрлэн, ярьсан нандин, эрхэм үнэт зүйл нь яг юу байв? гэдэг асуултад хариулт хайж задлан шинжилж дараах үр дүнг гаргалаа.

Хүснэгт 12. Ярилцагчийн онцгойлон дурдсан үнэт зүйлс

Нэвтрүүлэг	Ярилцагч	Түлхүүр үнэт зүйл
------------	----------	-------------------

Монгол тулгатны 100 эрхэм 1	Тэнгэр	<i>Үндэстэн</i>
Монгол тулгатны 100 эрхэм 2	Боржгин Гэрэлт	<i>Чингис</i>
Монголын үндэсний цаг 1	Ломбын Эрхэмбаяр	<i>Хамт олон</i>
Монголын үндэсний цаг 2	Дамдины Баярсайхан	<i>Хамт олон</i>
Чөлөөт ярилцлага 1	Тэнгэр	<i>Үндэстэн</i>
Чөлөөт ярилцлага 2	Нацагийн Жанчинноров	<i>Үндэстэн</i>
Хүмүүн тууль 1	Загдсүрэн	<i>Монгол соёл</i>
Хүмүүн тууль 2	Бадайн Бурам	<i>Мэргэжил, боловсрол</i>

“**Үндэстэн**” хэмээх үнэт зүйл нь “Монгол” гэсэн утгыг давхар агуулдаг.

“Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэгт алдарт дуучин Тэнгэр Монгол улсад ирж ярилцагчаар оролцохдоо үндэстний үзэл нь илүү их сэргэж, үндэстэнээрээ бахархах, хайрлах сэтгэлээ нээлттэй илэрхийлж маш чөлөөтэй ярьсан нь ажиглагддаг. Ер нь Тэнгэр бол өөрийн гэсэн нийгмийн байр суурьтай, бишрэм авъяасаараа олонд хүндлэгдсэн хүмүүн учраас үндэстний үзэл нь төдийчинээ эрхэм өндөр байдаг. Тэгэхлээр үндэстнийг төлөөлж байгаа өөрийнх нь эрхэм үнэт чанар, үндэстнийг төлөөлж чаддаг үзэл санаа нь нэгэнт бүрэлдсэн хүмүүн учраас “үндэстэн” хэмээх үнэт зүйлийг их чухалчилж ярьдаг нь **“Би ямар нэг шийдвэрлэж дийлэхгүй бэрх явдал таарвал өөрийгөө “би монгол болсны хувьд заавал чадах хэрэгтэй” гэж зоригжуулдаг”** гэх ярьснаас тодорч байна. Үүнийг “Чөлөөт ярилцлага”-д орохдоо бас тодорхой хэмжээнд ярьсан боловч агуулга, хэмжээ талаасаа нилээд бага, хөнгөн болсон байдаг. Тухайлбал “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэгт энэхүү үнэт зүйлийг 10 удаа дурдсан байдаг бол, “Чөлөөт ярилцлага”-д

- *Сүүлээр нь бодохлоор энэ дуу бол бүх монголчууд уулзахад гүүр болсон*

- *Би бол монгол хүмүүн учраас хамтлагийнхаа нэрийг заавал монгол хүнтэй холбоотой нэр авна гэж сэтгэж авсан юм*

- *Тэнгэр нэрэмжит дуу бүжгийн бүлгэмийг байгуулъя гэж бодож байна. Жинхэнэ монгол дуу урлагийг дэлхийд гаргана”* зэргээр гурван удаа л ярьжээ.

Харин Нацагийн Жанчинноров гуай Өвөр монголд ирж “Чөлөөт ярилцлага”-д оролцохдоо ар, өвөр монголын ахан дүүс бид нэг л үндэстэн юм гэдгийг эрхмийн эрхэм болгон 8 удаа ярихдаа **“Би анх Өвөр монголд 89 онд ирч байсан.Түүнээс хойш тасралтгүй ирж л байна. Ер нь бол энд ирээд нэг ч удаа гадаадад ирчихлээ гэсэн сэтгэгдэл төрдөггүй”, “Миний хувьд энэ монгол улсын, өвөр монголын гэсэн ухагдахуун байхгүй. Адилхан монгол үндэстэн”** гэж энгийн хэрнээ утга учиртай ярихын дээр:

- ***Ер нь гаднаа монгол байхаасаа дотор монгол байх юмсан гэж тэгж л шатаж явдаг хүмүүн шүү дээ.***

- *Монгол хүмүүн монгол хүмүүн шиг байгаасай л гэж боддог*

- ***Хэдийчинээ өөрийнхөө үндэс угсаа, үндэстэний сэтгэлгээ, үндэстний амьдрах арга зарчмаа гүн хадгалж чадна уу төдийчинээ л удаан тэснэ***

гэх мэтчилэн үндэстний үзлийн өөрийн гүн сэтгэмжээ ярьсан нь үндэстэн оршин тогтнохын төлөө сэтгэлээ чилээж явдаг эрхэмлэл, чин итгэлийг нь илтгэжээ.

“**Чингис**” хэмээх үнэт зүйл нь өвөг дээдсийн баатарлаг түүхийн бэлгэ тэмдэг, монгол үндэстний бахархал юм.

Эрдэмтэн Боржгин Гэрэлт “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэгт орохдоо үнэхээр нийт монголчуудын, дэлхийн хэмжээний эрдэмтэн гэдгээ сэтгэж байгаа үйл, хийж байгаа ажил, ярьж байгаа үг бүхнээрээ харуулсан байдаг. Тэр яриныхаа дунд нэлээн олон удаа эх хэлнийхээ төлөө

санааширч явдагаа илэрхийлж байсан ч нэвтрүүлгийн оргил болгон эзэн “Чингис” хаан бол өөрийнхөн төдийгүй энэ монгол хүмүүн бүхний хамгийн дээд эрхэм үнэт зүйл гэдгийг онцгой илтгэн ярьжээ:

- Намайг зовж зүдэрсэн үед **эрчилж урагшлуулдаг хүчин бол “Чингис”** байгаа юм. Энэ бол үнэн үг
- **Чингис хаангүй бол монгол хүнгүй, Боржгин Гэрэлтгүй**
- **Чингис хааныг манай бүх монголчууд “Бурхан” шиг шүтээсэй** гэж би боддог.
- Энэ бурхан бол миний ойлгодог “Бурхан”.

гэхчлэн “Чингис”-ийг бурханчлан шүтэх үзлээ тал бүрээс нотлон тайлбарлаж ярьжээ.

“Хамт олон” хэмээх үнэт зүйл нь “Монголын үндсэний цаг” нэвтрүүлэгт үндэстэний зочноор оролцсон Ломбын Эрхэмбаярын итгэл үнэмшил, эрхэмлэл юм. Мэдээж энэ компанийг үүсгэн байгуулснаараа тэр бахархдаг. Гэхдээ түүний бахархалт хамгийн үнэт зүйлээ хамт олныхоо хүчинд босгосон гэдгээ ямагт эрхэмлэж явдаг нь ярилцлагад нь олонтаа дурдагдсан юм. Тэгвэл Улсын хошой аварга малчин Дамдны Баярсайхан гуай эхнэрийн хамт “Монголын үндсэний цаг” нэвтрүүлэгт оролцохдоо эртнээс өдгөө хүртэл өвсний соргог усны сайныг сонгож малжиж ирсэн нүүдэлчин малчин монголчууд мал унаагаа хамтран арчилж додомдох, ноос ноолуурын цагт хамтран ажиллах, зуд зурханыг хамтран туулах гээд амьдралын салбар бүрд хамт олны хүчинд түшиглэхийн чухал чанарыг эрхэмлэж явдагаа ярьжээ. Тиймээс ч хамт олныхоо тус дэмийг юм юмны түрүүнд тавих, хамтрагчдаа хайрлан хүндлэх, ус нутаг, түмэн олноо хамтад нь бодож явдаг нь чанартай аж.

- *Малчидтайгаа аль болох ойрхон байж, урамшуулж, малчдын амьдрал ахуйг дээшлүүлэхийн төлөө л хамтарч ажилладаг гэж боддог шүү.*

гэж ярьсан нь үүнийг илтгэж байна.

Мэргэжил, боловсрол Бадайн Бурам гуайн хувьд түлхүүр үнэт зүйл нь байлаа. Энэ нь түүний дүр төрх, үнэт зүйлийн бүрдүүлбэр зэргийн судалгаанд тодорхой ажиглагдсан. Мэргэжлийн нэвтрүүлэгч болохын хувьд “мэргэжил” өөрийг нь бүтээсэн гэдгийг ямагт эрхэмлэж явдаг нь тодорхой ажиглагддаг.

Ийнхүү “үндэстэн”, Чингис”, монгол соёл”, “хамт олон”, “мэргэжил, боловсрол зэрэг цөөн үнэт зүйл нэвтрүүлгийн зочид болох 8 тодорхой ярилцлагчийн түлхүүр үнэт зүйл нь болох нь батлагдаж байна.

ДҮГНЭЛТ

Монгол улс болон Өвөрмонголын радио, телевизийн хөрөг нэвтрүүлгүүдээс сонгон судалсан нэвтрүүлгүүд ур чадвар, ярилцлагын зорилго, ач холбогдлоороо бусад нэвтрүүлгүүдээсээ ялгарч чадсан чанартай бүтээлүүд болох нь ажиглагдлаа.

Эдгээр нэвтрүүлгүүдэд оролцсон оролцогчдын хувьд өөр өөрийн гэсэн эрхэмлэн нандигнадаг итгэл үнэмшил, үнэт зүйлстэй болох нь тодорхой мэдэгдэж байна. Тэдний ярилцлагын явцад хамгийн багадаа нэг нэвтрүүлэгт ярилцагч 4 үнэт зүйлээ сөхөж ярьсан бол хамгийн олонхидоо 13 үнэт зүйлийг нээж ярьсан байна. Энэ бол эрхэм хүмүүсийн мөн чанар, итгэл үнэмшил бөгөөд нэвтрүүлгээр дамжин үзэгчдэд нөлөөлөх чухал утга агуулга юм. Тэдгээр үнэт зүйлсээ тайлбарлан ярихын зэрэгцээ нандигнах, бас эмзэглэх сэтгэл сэтгэлгээгээр ярьж байгаа нь нэвтрүүлгийн зорилго биелснийг илтгэж байлаа.

Ярилцагчдын үнэт зүйлс нь үндэсний ухамсар сэтгэлгээ, өв соёлоос эхлээд боловсрол, хань ижил, ирээдүй хойч үе гээд 17 төрөл байх бөгөөд тэдгээрийг ямар үнэ цэнтэй болохыг ярилцагчдын яриа илтгэж байлаа.

Эцэст нь дүгнэвэл хөрөг ярилцлага бол ярилцагчийнхаа дүр төрхийг шинээр нээх, түүний эрхэмлэх үнэт зүйлсээр дамжуулж ярилцагчийн итгэл үнэмшил, етрөнцийг үзэх үзэл, эрхэм чанаруудыг нээх харуулах зорилго тавьдаг байна.

Study values of the ‘Dear Guest’ in a portrait interview

Amartuvshin Sukhee 

Assistant professor, Department of Journalism, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Amuer 

Doctoral student, Department of Journalism, School of Social Sciences and Humanities of the Mongolian National University of Education, Mongolia

Amuerjirigala

Department of Journalism, School of Social Sciences and Humanities of the Mongolian National University of Education, Mongolia

Abstract

An important topic of content research is studying ‘the value’ of the dear guest in a portrait interview. Famous people have their own values. Therefore, it is important to clarify the skills and content of the program, studying the values of the ‘Mongolian gentleman’ who is the subject of the portrait interview program. In this article, we set the task of studying the values of the interviewer in the interview program ‘Gentleman’, recently released in Mongolia and Inner Mongolia, using a special technique and comparing it. The study found that ‘gentlemen’ have common and unique values that indicate the character of the owner.

Keywords: portrait interview, guest interviewer, gentleman, values, frequency of values

НОМ ЗҮЙ

Батбаатар.Ж. (2023). Суурь сэтгүүл зүй. Улаанбаатар.

Бэлгүүнзаяа.С. (2022). Телевизийн хөрөг нэвтрүүлгийн уран чадварын зарим асуудалд.

Сэтгүүл зүй, 23(581), 89. Улаанбаатар.

<https://journal.num.edu.mn/journalism/article/view/6876>

Зулькафиль.М. (2004). Сэтгүүл зүйн тайлбар толь. Улаанбаатар.

Норовсүрэн.Л. (1995). Сонины бичлэгийн төрөл зүйл. Улаанбаатар.

Санчес, А. К. (2000). Үнэт зүйлсийн төлөвшил: онол, эргэцүүлэл ба хариулт. Мексик: Григалбогийн редакц.

Fischer, C. A. (2019). Werte als Kerne von Kompetenzen. Eine theoretische Studie mit einer empirischen Analyse in Montessori-Schulen. Waxmann Verlag GmbH.

John Erpenbeck, W. S. (2018). Wertungen, Werte - Das Fieldbook fuer ein erfolgreiches

Wertemanagement. Berlin, Heidelberg.: Springer.

<https://doi.org/10.1007/978-3-662-54779-3>

Paul H. P. Hanel, C. F. (31 August 2021). Psychology.

<https://doi.org/10.1093/acrefore/9780190236557.013.248>

Schwartz, S. (2006). Are there Universal Aspects in the Structure and not Content of Human Values? In M. Ros, & V. Gouveia (Eds.). *Social Psychology of Human Values: Theoretical, Methodological and Applied Developments*, pp. 55-85.

Sukhee, A., & Tsevegjav, T. (2024). Framing studies: stereotypes about Mongolia's in the American Press (1868-1968). *Cogent Arts & Humanities*, 11(1).

<https://doi.org/10.1080/23311983.2024.2303178>